



АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО
НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН ХУУЛИЙН ЭТГЭЭД



ТӨВ АЙМГИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХОЛБООНЫ 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

ТААЖХолбооны танилцуулга

- Төв Аймгийн Аялал Жуулчлалын салбар дахь бүх оролцогчдыг төлөөлсөн дээвэр байгууллага байж гишүүдийнхээ нийтлэг эрх ашиг сонирхлыг хамгаалан, Аялал Жуулчлалыг эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлэхэд Төр,Хувийн хэвшлийг холбож ажиллах зорилгоор 2009 онд анх “Эвт төв” ТББ нэртэйгээр байгуулагдаж байсан.
- 2017 оны 8 сарын 29-нд ТААЖХолбоо гэж нэрээ сольж дахин зохион байгуулагдсан.
- 2024 оны 6-р сард дүрмэндээ өөрчлөлт оруулан АЖМХ НЭЗХЭ-ийн бүрэн эрхэт салбар холбоо болсон (24 гишүүн).
- Тус Холбоо нь одоогоор 32 гишүүнтэй.

ТӨВ АЙМГИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХОЛБООНЫ 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН

2024-12-10-нд Төв аймгийн бүх гишүүдийн хурлаа зарлан аймагт аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг ААН-үүдийн захирал болон менежерүүдэд мэдээ мэдээлэл, бизнесийн хамтран ажиллах саналыг тус тус танилцуулсан. Үүнд:

- ЗГ-ын бүтэц өөрчлөгдсөнтэй холбоотойгоор БОУАӨГ-ын дарга Ж.Даш-Яйчилын оронд Төв аймгийн ССАЖЗГ-ын дарга Б.Тунгалагад ТААЖХ-ны удирдах зөвлөлийн гишүүнээр ажиллах болсон.
- АЖМХ-ны гүйцэтгэх захирал М.Нарангэрэлийг урьж, Төв аймгийн гишүүдэд АЖМХ НЭЗХЭ тухай, үйл ажиллагааны талаар бүрэн мэдээлэл хүргэсэн.
- И-Март дэлгүүрийн худалдааны маркетингийн албаны төлөөлөгчид хүрэлцэн ирж ААН-үүдэд хүнсний аюулгүй нөхцөлийг хангасан бараа бүтээгдэхүүнийг ойролцоо бүсэд байрлаж буй жуулчны бааз, амралтын газруудад хүргэлтийг хийх боломжтой эсэх талаар судласан.
- И-Март ХХК шинэлэг амттан десертний төрлөөсөө амталгаагаа танилцуулсан.

Go Mongolia Tourism Awards-д ТААЖХ-ноос гишүүн байгууллагуудаасаа шагналд тодорхойлсон.

- Оны шилдэг Хөрөнгө оруулагчаар “Түмэн Амгалант Асар” ХХК
 - Оны шилдэг Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын үйлчилгээ эрхлэгчээр Төв аймгийн Алтанбулаг сумын “Баянсонгинот” малчдын бүлэг шалгарсан.
-



MONGOLIA

ALWAYS · MOVING ·

2024.12 27

"Go Mongolia"
Tourism Award 2024 оны
шилдэгүүдээ тодруулав

by.MTO

2024.12.24-ний өдрийн
байдлаар Монгол Улсад
803,105 жуулчин
ирсэн байна



Монгол Улсын Засгийн
газраас "Монголд очлох
жил"-ийг 2028 он хүртэл
сунгав

TOURISM
AWARDS

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ



MONGOLIA

ALWAYS · MOVING ·

2024.12 27

"Go Mongolia"
Tourism Award 2024 оны
шилдэгүүдээ тодруулав

by.MTO

2024.12.24-ний өдрийн
байдлаар Монгол Улсад
803,105 жуулчин
ирсэн байна



Монгол Улсын Засгийн
газраас "Монголд очлох
жил"-ийг 2028 он хүртэл
сунгав

TOURISM
AWARDS

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ



MONGOLIA
ALWAYS · MOVING ·

TOURISM WEEK
2025

БҮРТГЭЛ
ЭХЭЛЛЭЭ

📅 **2025.02.10-14**




7712 8822 ✉ tourismweek@gomongolia.mn

www.tourismweek.mn

АЖМХ НЭЗХЭ-ээс зохион байгуулдаг хурал, уулзалтуудад салбар холбооны хариуцлагаа биелүүлэн ТААЖХ -ны төлөөлөл УЗГ-үүд тогтмол идэвхтэй оролцдог.

Үүнд:

- 2025 оны 1-р сарын 10-ны өдөр АЖМХ-ны Салбар холбоодын Гүйцэтгэх удирдлагуудыг АЖМХ-ны Гүйцэтгэх захирал М.Нарангэрэл тэргүүтэй ажлын албаны хамт олон хүлээн авч уулзав.
- 2025/02/10-14 Аялал жуулчлалын Долоо хоног арга хэмжээнд бүрэн бүрэлдэхүүнээр оролцов.
- 10 сард салбар холбоодын удирдлагуудын уулзалтад оролцов



ТУРШЛАГА СОЛИЛЦОХ АЯЛАЛД ТА БҮХИЙГ УРЬЖ БАЙНА



ЖББХСХ-ноос гишүүн байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх, туршлага солилцох зорилгоор

Т.САРУУЛ ЗАХИРЛЫН САНААЧИЛГААР

Төв аймагт байрлах "Овооны Энгэр" жуулчны баазтай танилцах нөхөрсөг аялал зохион байгуулагдана.

Хугацаа: 2025.03.22 /Бямба гариг/
10 цагт Манзушир хийд дээр цуглая

Өдрийн сонголт:
Өдрөөр эсвэл Хоногоор

Тээврийн хэрэгсэл: Өөрсдийн унаагаар
Холбогдох дугаар: 99083229 Т.Саруул, 99093339 М.Оюун



Туршлага солилцох аялал

2025 оны 3-р сарын 22-ны өдөр ЖББХСХ-оос гишүүн байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх, туршлага солилцох зорилгоор ТААЖХ-ны УЗГ Т.Саруул захирал нь "Овооны энгэр" амралтын цогцолборт зохион байгуулсан.

Энэхүү арга хэмжээнд ТААЖХ-ны гишүүд идэвхтэй дэмжин оролцсон.

Өдөрлөг нь Төв аймгийн 9-н гайхамшигийн нэг Манзушир хийд дээр цугларан хангай дэлхийдээ өргөх идээний дээж сүү, арвай будаагаа Т.Саруул гишүүнээс авсанаар өглөөний аялал эхэлсэн.

Манзуширын хийд, болон музейг үзэж танилцан Манзушир хийдийн лам нар олз омог ажил үйлсийн ном уншиж дууссанаар өглөөний аялал өндөрлөн "Овооны энгэр" амралтын цогцолбор руу хөдлөн баазын үйл ажиллагаатай танилцсан юм.

ТУРШЛАГА СОЛИЛЦОХ ӨДӨРЛӨГТ оролцох нь бие биенээсээ суралцах том боломжийг олгодоггоос гадна нөхөрсөг найрсаг харьцааг үүсгэдэг онцлогтой.

Энэхүү арга хэмжээг Т. Саруул УЗГ нь үнэхээр зохион байгуулалттай, чин сэтгэлээсээ зохион байгуулсаныг онцлууштай байсан.



ТӨВ АЙМАГ ДАХЬ ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖТЭЙ ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭГ БАЙГУУЛАВ.

Тус коллеж нь тогооч, үсчин, барилгачин, сантехникч, гагнуурчин зэрэг чиглэлээр боловсрол олгодог.

- 9-11 сард 2-р курсын оюутнууд цалинтай дадлагын ажил хийлгэх.
 - Аялал жуулчлалын улиралд /6-8 сарууд/ гэрээгээр ажиллуулахаар тохиролцсон. Тогоочийн ангийн оюутнуудыг -туслах тогооч, бэлтгэгчээр, бусад суралцагчдыг -үйлчилгээний чиглэлээр ажиллуулсан.
 - 7 ААН 15 сурагчтай хамтран ажиллав.
-



ӨМӨЗО-ны АЖ-ын байгууллагатай хамтын ажиллагааны гэрээ байгууллаа.

/ 2025/04/13-14/

Төв аймгийн ЗДТГ-аас ӨМӨЗО-ны Аялал жуулчлал, ХАА-н чиглэлээр хамтран ажиллах уулзалтыг Хөх хотод зохион байгуулсан.

Тус уулзалтад ТААЖХ-г төлөөлж УЗ-ийн гишүүн “Монголын тал нутаг” жуулчны баазын захирал Г.Цэцэгдулам оролцож холбогдох албаны болон аж ахуйн нэгжүүдийн төлөөлөлтэй уулзаж хамтын ажиллагааны гэрээ байгуулсан.

ТААЖХ-ны гишүүд Туршлага солилцох, цаашдын хамтын ажиллагааг өргөжүүлэх өдөрлөгийг хийхээр төлөвлөж байна.





● **“БАРГАЖИН-2025” ОЛОН УЛСЫН
СОЁЛ УРЛАГ, СПОРТЫН 6 ДУГААР
ИХ НААДАМ** 2025/08/08-11/

- ЗД-ын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг
 - ССАЖЗЯ
 - Барга судлалын холбоо
 - ТААЖХ
-
- Дорнод аймагт 4 удаа,
 - ОХУ-д 1 удаа зохион байгуулагдаж байсан




ОЛОН УЛСЫН СОЁЛ УРЛАГ, СПОРТЫН НААДАМ

“Баргажин-2025” ОУСУС-ын наадамд

- Өвөр Монголын Барга угсааны 350 гаруй төлөөлөгчид
- Дорнод, Говьсүмбэр, Хэнтий, Сүхбаатар аймаг, Улаанбаатар, Зуунмод хот, 27 сумын төлөөлөл иргэд оролцсон.
- Солонгос, Хятад, ХонгКонг, Орос, Франц зэрэг улсын 100 орчим жуулчид ирж сонирхсон
- “Алтан туурайн гайхамшиг” компанийн “Сэртэн” морьтон цогцолборын морин циркийн үзүүлбэр.



ОЛОН УЛСЫН СОЁЛ УРЛАГ, СПОРТЫН НААДАМ



• ITM 2025



- Төв аймгийн ЗДТГ-аас 10 гаруй сая төгрөгний санхүүгийн дэмжлэгийг үзүүлэн хамтран ажиллав.
- Үзэсгэлэнд оролцсон 14 байгууллага 5000 гаруй танилцуулга брошур тарааж, давхардсан тоогоор 400 гаруй тур оператор компаниудтай гэрээгээ шинэчлэн байгуулсан.
- Төв аймгийн нэгдсэн газрын зургийг шинэчлэн хэвлүүллээ



Орлого

№	Гүйлгээний утга	Гишүүнчлэлийн хураамж
Эхний үлдэгдэл		2,816,388.32
1	Гишүүнчлэлийн татвар /2024 он/	7,100,000
2	ITM2025 – Оролцсон компаниудын зардал	14,250,000
3	ITM2025- Төв аймгийн ЗДТГ	10,860,000
Нийт дүн		35,026,388.32

Орлого

35,026,388.32

**Үлдэгдэл
мөнгө**

Зарлага

19,028,302

15,998,086.32



ТААЖХ-ны удирдах зөвлөлийн гишүүд



- ТААЖХ-ны 2025 оны бүх гишүүдийн хурал 11-р сарын 14-ний өдөр болсон. Тус хуралд 22 гишүүн байгууллага оролцож 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан 2026 оны төлөвлөгөөг хэлэлцэн баталсан.
- Тус хурлаар ТААЖХ-ын тэргүүнээр “Монгол Сафари” ХХК-ийн “Чандмань тур” амралт жуулчны баазын захирал Б. Төгсжаргал сонгогдсон.

ТААЖХ-ны 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөө

№	Хийхээр төлөвлөсөн ажилууд	Хугацаа	Хэн хариуцах	Хамтран хэрэгжүүлэгч	Төсөв (мян.төг)	Нэмэлт тодруулга
1	"Төв аймагт Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгчдийн Чуулга, үүлзалт"-ыг зохион байгуулахад хамтран ажиллах	1-р улирал	УЗ	ЗДТГ, ССАЖЗГ		Аймгийн санхүүжилтээр
2	Аймгийн хэмжээнд идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа аялал жуулчлалын байршуулах хэрэгслийн судалгааг хийж, нэгдсэн сан үүсгэх	1-2 улиралд	УЗ	Гишүүд, ССАЖЗГ		
3	Төв аймгийн Аялал жуулчлалын шинэ маршрут, бүтээгдэхүүн гарган сурталчлах	2-3 улирал	УЗ	ССАЖЗГ, ААЖЗөвлөл, гишүүд	Төсөв батлуулж танилцуулах	Аймгийн болон оролцогч ААН-үүдийн санхүүжилтээр.
4	АЖМХ-ноос зохион байгуулах үйл ажиллагаанд хамтарч оролцох	жилийн турш	УЗ	Гишүүд		Оролцогч ААН өөрийн зардлаар
5	Уламжлалт "Хонины найр" эвентийг зохион байгуулах	8-р сарын 2	УЗ	Баянсонгинот бүлэг, ССАЖЗГ	1,000,000.0	
6	"Алтан Хайч" эвентийн зохион байгуулалтад оролцох	6-р сар	УЗ, гишүүд	ЗДТГ, ССАЖЗГ		Аймгийн санхүүжилтээр
7	Татвар болон Нийгмийн даатгал, бусад тайланг зохих хугацаанд нь гаргаж, баталгаажуулалт хийлгэж байх	жилийн турш	Тэргүүн	УЗ, Хяналтын зөвлөл	1,000,000.0	
8	Өвлийн аялал жуулчлалын хөтөлбөрөө сайжруулан үргэлжлүүлэн сурталчлах	12-3 сард	УЗ	Хамрагдах баазууд		Өөрсдийн зардлаар
9	ЕАТОФ-ийн гишүүн мужуудтай хамтран ажиллах, туршлага солилцох	жилийн турш	УЗ	ЗДТГ, ССАЖЗГ, гишүүд		Филипин Сэбү муж
10	Туршлага судлах аялал зохион байгуулах / дотоод болон гадаад/	Хавар, намар	УЗ	гишүүд		өөрсдийн зардлаар
11	Сургалт зохион байгуулах	2-р улирал	УЗ	АЖМХ, ЗДТГ, ССАЖЗГ, ААЖЗөвлөл		төлбөртэй хийх
12	ITM үзэсгэлэн яармагт оролцох	10-р сард	УЗ	Гишүүд, ЗДТГ, ССАЖЗГ	25.000.000	Аймаг болон оролцох компаниудын санхүүжилтээр
13	УЗ-ийн хурлыг улирал тутам зохион байгуулах	жилийн турш	Тэргүүн	УЗ		
14	ТААЖХ-ны пейж хуудас, веб сайтыг идэвхжүүлэх	жилийн турш	УЗ		1,000,000.0	
15	2026 оны ажлыг дүгнэх арга хэмжээ зохион байгуулах	11-р сард	Тэргүүн, УЗ	гишүүд	2.000.000	



- ТААЖХ 2025 онд УЗ-ийн хурлаа биечлэн болон цахим хэлбэрээр 4 удаа зохион байгуулан
- АЖМХ-ноос зохион байгуулж буй үйл ажиллагаанд хэрхэн оролцох
- 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан ажлын биелэлт
- АЖМХ гишүүн байгууллагын татвар төлөлтйн асуудал
- ITM 2025 хэрхэн оролцох зэрэг цаг үеийн асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэсэн.
- 11 сарын 3-нд Төв аймгийн Засаг дарга Л. Төмөрчөдөртэй уулзаж 2026 онд хамтран ажиллах чиглэлээ хэлэлцсэн.
- ТААЖХ 2025 оны 11-р сарын 14-нд өдөр бүх гишүүдийн хурлаа хийсэн.

БАЯРЛАЛАА!